



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/74

Өвт

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.4, 46.1.6 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийг үндэслэн Эрүүл мэндийн төвийн эмчлүүлэгсдийн хоол, хүнсний материал нийлүүлэх тендерийг “Батгэгээн хангай” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. “Батгэгээн хангай” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (О.Отгонболд)-д даалгасугай.

3. Эрүүл мэндийн төвийн эмчлүүлэгсдийн хоол, хүнсэнд шаардагдах зардалд 14.999.900 (Арван дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга есөн зуун) төгрөгийг гэрээний дагуу санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч (Г.Болормаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

05101014